



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/247

Мандалтөвь

Түр хамгаалах байрны  
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Төсвийн тухай хуулийн 16.5.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.1.1, 19.1.3, 19.1.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.5.5, “Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэл”-ийн 3.5.1 дэх заалтууд болон аймгийн Засаг дарга, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга нарын байгуулсан “Хамтран ажиллах тухай” гурвалсан гэрээний 2.1.5, 2.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалан түр байрлуулах, хүүхэд хамгаалал, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах зорилгоор “Түр хамгаалах байр”-ны тогтмол зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Түр хамгаалах байрны тогтмол зардалд шаардагдах 1,200,000 (Нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тогтмол зардлын хэмнэлтээс гарган зарцуулахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ц.Ганзориг) -т зөвшөөрсүгэй.

Гурав. “Түр хамгаалах байр”-ын үйл ажиллагааг эрчимжүүлэн, нийгэмд үзүүлэх үйлчилгээг чанартай зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа)-т, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (Ц.Ганзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О. БАТ-ЭРДЭНЭ

482013863

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дугаар сарын 16-ны өдрийн 09 дугаар захирамжийн хавсралт

**“ГОВИЙН БУС”-ИЙН ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ 2020 ОНД  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Хэмжээ	Сард	НӨАТ	Жилд
1.	Халаалт	м <sup>2</sup>	500	148	74,000	7,400	596,000
2.	Цахилгаан	кВт	128	хэрэглээ дундаж 400кВт	31,200	3,120	411,840
3.	Хог, МҮОНТ-ийн хураамж	-	2850	1	2850	285	37,620
4.	Цэвэр бохир усны төлбөр	л	3.300	Хэрэглээ дундаж 2 тн	6,600	660	87,120
5.	Бусад	ш	67,420	1	-		67,420
<b>Нийт дүн</b>							<b>1,200,000</b>